



ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН
ТУШААЛ

2019 оны 08 сарын 02 өдөр

Дугаар A/39

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

“Донорын тухай” хуулийн 7.1.5, 19.1, Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/137 дугаар тушаалын 7.1.7.7 дах заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн сайдын 2013 оны А/37, 2016 оны А/01, А/02 дугаар тушаалыг шинэчлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажлын хэсгийн удирдамж, ажил үүргийн хуваарилалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Дээрх тушаалыг нотолгоонд үндэслэн шинэчилж, удирдамжийг мөрдөн, идэвхи санаачлагатай ажиллахыг Ажлын хэсгийн гишүүдэд үүрэг болгосугай.
3. Тушаалын төслийг боловсруулж 2019 оны 10 дугаар сарын 1-ний дотор Эрүүл мэндийн яаманд албан бичгээр хүргүүлэхийг Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга /Т.Алимаа/-д үүрэг болгосугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудитор /Д.Амар/-т даалгасугай.


ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Н.ЭРДЭНЭБАЯР

080062

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын 2019 оны
08 дүгээр сарын 08-ний өдрийн
А/39 тоот тушаалын нэгдүгээр хавсралт



Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ахлагч: Н. Эрдэнэбаяр, Ерөнхий захирал

Нарийн бичгийн дарга: Т. Алимаа, Чанар, цусны сонор сэрэмжийн албаны дарга

Гишүүд: Ч. Батболд, Стратеги төлөвлөлт, санхүү бүртгэлийн албаны дарга

О. Ариунсувд, Статистикч, Эдийн засагч

Э. Тунгалагтуяа, Чанарын менежер

Ё. Улсболд, Донор зохион байгуулалтын тасгийн эрхлэгч

Р. Энхтуяа, Донор зохион байгуулалтын тасгийн их эмч

Х. Мядагмаа, Донор зохион байгуулалтын тасгийн их эмч

Г. Цэндбаяр, Донор зохион байгуулалтын тасгийн их эмч

Д. Дулмаа, Донор зохион байгуулалтын тасгийн Нийгмийн ажилтан

Ж. Энхбат, Донор зохион байгуулалтын тасгийн Олон нийттэй харилцах менежер

Н. Халиун, Технологийн тасгийн эрхлэгч

Д. Наранхүү, Технологийн тасгийн их эмч


М. Цэрэндэжид, Нэгдсэн лабораторийн эрхлэгч

Э. Отгонжаргал, Нэгдсэн лабораторийн Био-Анагаахын мэргэжилтэн

Б. Мөнхжаргал, Мэдээллийн технологи, инженер техникийн тасгийн эрхлэгч

Ц. Энхмэнд, Мэдээллийн технологи, инженер техникийн тасгийн инженер

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын 2019 оны
08 дүгээр сарын 02-ний өдрийн
А/39 тоот тушаалын хоёрдугаар хавсралт



Ажлын хэсгийн мөрдөх журам

Нийтлэг үндэслэл:

Монгол улсын "Донорын тухай" хуулийг 2017 онд шинэчлэн найруулж, зарим өөрчлөлт нэр томъёо шинэчлэгдсэн. Төвийн үйл ажиллагаанд хэрэгжиж байгаа тогтолцооны стандартуудын шалгуур үзүүлэлтэнд баримт бичгийн түвшнээс хамаарч 1-3 жил тутам хянаж, шинэчлэн сайжруулах шаардлага тавигдаж, аудитын явцад хянаж, үнэлдэг.

ЭМ-ийн сайдын 2013 оны 37 тоот тушаалаар цус бүлэгнэлтийн эмэг эмчлэх цэвэршүүлсэн факторыг захиалах, нийлүүлэх, хадгалах, олгох, зарцуулалтыг тайлагнах, 2016 оны 01, 02 тоот тушаалаар цусны албаны үйл ажиллагааны журам, заавруудыг баталсан. Иймд төвийн алба, тасгууд, тушаалын заалт, хавсралт бүрийг холбогдох үүргийн дагуу уншиж судлан холбогдох шинэчлэл өөрчлөлтийг хийх шаардлагатай байна.

Ажлын хэсгийн удирдамж:

1. Шинэчлэгдсэн тушаалд цусны албаны бүх үйл ажиллагаа тусгагдана.
2. 2013 оны А/37, 2016 оны А/01, А/02 тоот тушаалыг сайтар судлах мөн холбогдох хүчинтэй байгаа бусад тушаалуудыг судална.
3. Хэрэгжүүлэх явцад гарч байгаа бэрхшээлүүдийг алба, тасаг, орон нутгийн цусны салбар төвтэй холбогдож зөвшилцөнө.
4. Шинэчилсэн тушаалаар батлагдсан журам, заавар нь үндэсний хэмжээнд цусны аюулгүй байдлыг хангах цогц үйл ажиллагаанд мөрдөх тул заалт, хавсралтуудыг ЦССҮТ, орон нутгийн ЦСТ, сумын түвшинд гэж зааглан гаргаж өгнө.
5. Олон улсын сайн туршлага, ижил төрлийн баримт бичгийг уншиж судлан нотолгоо, үндэслэлийг бүрэн, сайн бүрдүүлнэ
6. Тушаалыг шинэчилсэн эхний төслийг 9 сарын 05-ны дотор боловсруулж, 9 сарын 19-ний дотор төвийн удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлж, 10 сарын 01-ний дотор ЭМЯ-нд хүргүүлсэн байна.

Ажил үүргийн хуваарилалт:

Ажлын хэсгийн ахлагч: Ажлын хэсгийг удирдан зохион байгуулж, мэргэжил арга зүйгээр хангана.

Нарийн бичгийн дарга: Ажлын хэсгийг хурал зохион байгуулах, протокол хөтлөх, хурлын шийдвэрийг гишүүдэд түгээн баримтжуулах, гишүүдийн боловсруулсан материалыг цуглуулж, нэгтгэх, албан бичгээр ЭМЯ-д илгээх

Гишүүд: Ажил үүргийн чиглэл, хуваарийн дагуу тушаалын төслийг боловсруулах ажлыг алба, тасгийн эмч, мэргэжилтэн, Цусны салбар төвтэй хамтран боловсруулах эмч, ажиллагсдын боловсруулсан төсөл, саналыг авч, хянан нэгтгэх, хянасан төслөө нарийн бичгийн даргад хугацаанд хүргүүлэх, ажлын хэсгийн хуралд танилцуулах, ажлын хэсгийн хурлаас гарсан санал, зөвлөмжийг тусган засвар хийн эцсийн хувилбарыг ажлын хэсгийн нарийн бичгийн даргад цахим шуудангаар хүргүүлнэ.

Донор зохион байгуулалтын тасаг: Цусны донорын сургалт, сурталчилгаа, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах, сайн дурын ажилтан бэлтгэх, цусны донорын нийгмийн асуудал, алдаршуулалт, урамшуулал, цусны донорын сургалт, донорын бүртгэл, шилжилт хөдөлгөөн, сонголт, бүхэл, цус, сийвэн, эс, 2 нэгж улаан эс сонгох нэмэлт шалгуур үзүүлэлт, ЭМ-ийн үзлэг, шалгуур үзүүлэлт, бүр түр хориглох заалт, эрсдэлтэй зан үйл илрүүлэх нэмэлт асуумж, үзлэг, нотолгоо, зөвлөгөө, цус, сийвэн, эс цуглуулах үйл ажиллагаа, Явуулын цус цуглуулалт, зохион байгуулалт, ЦЦБ –ний тээвэрлэлт, сар бүр 3, цусны донорууд, сайн дурын ажилтан, хамтран ажилласан байгууллагуудаас санал хүсэлт авах, түүний мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээ

Технологийн тасаг: ЦЦБ-ний хүлээн авах, чанарыг шалгах, бүртгэх, ЦЦБ-ний үйлдвэрлэлийн технологийн нийтлэг зарчим, анхаарах зүйлс, түр, болон удаан хугацааны хорионд хадгалах, хорионоос чөлөөлөх, ЦЦБ-ний захиалгыг эмнэлгийн тасаг, эмнэлгүүдээс хүлээн авах, бүртгэх, ЦЦБ-нийг эмнэлэгт олгохын өмнөх хяналт, шалгалт, эмнэлэгт олгох, ЦЦБ хадгалах, тээвэрлэх, ЦЦБ-ний ердийн болон гамшгийн үеийн нөөц бүрдүүлэлт, сэлгэлт, нөхөн хангалт, эмнэлгүүдээс хэрэглээний тайлан мэдээ авах, хяналт үнэлгээ хийх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, Алсын тээвэрлэлт УБ-аас орон нутаг, аймгаас сум руу

Цэвэршүүлсэн факторын худалдан авалт, захиалга хийн ханган нийлүүлэлт авах, хадгалах, эмнэлгүүдээс захиалга авах, олгох, зарцуулалтыг тайлагнах

Хэрэглэгч, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж судалгаа, хэрэгжүүлэх үйл ажиллагаа

НЛ-ийн тасаг: Цусны доноруудад хийгдэх шинжилгээ, цус, сийвэн, эс, 2 нэгж улаан эс цуглуулахын өмнөх шинжилгээ, хэвийн үзүүлэлт, сорьц хүлээн авах, бүртгэх, чанарыг шалгах, буцаах үзүүлэлт, цуглуулсан цусны бүтээгдэхүүн бүрд хийгдэх халдвар илрүүлэх болон бүлэг тодорхойлж, баталгаажуулах шинжилгээ, халдвар илрүүлэх, нэмэлтээр хийх шинжилгээний төрөл, ЦССҮТ, ЦСТ, сум гэж ангилан хийх арга, аргачлал, алгоритм, хэрэглэх оношлуурт тавигдах шаардлагын хамт тодорхой гаргах, сум, аймгаас ямар сорьцыг ямар үед аймаг, ЦССҮТ рүү илгээх тухай тодорхой тусгах, ийлдсийн сан хадгалах, ашиглах, утсгах,

ЦЦБ-д хийгдэх чанарын шинжилгээ, давтамж, үзүүлэлт, 3 түвшнөөр ялгаатай гаргах, ОУ-ын туршлага, нотолгоог сайн гаргах, бактериологийн шинжилгээ төрөл, арга, давтамж,

Трансфузиологийн лавлагаа шинжилгээ, нэр төрөл, ямар тохиолдолд ямар сорьцыг хэрхэн тээвэрлэх, хариу олгох, үндэсний ЧГҮ-ний хөтөлбөр зохион байгуулалт, хамрагдахад анхаарах зүйлс, мэргэжил арга зүйн дэмжлэг, зөвлөгөө

Хэрэглэгч, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж судалгаа, хэрэгжүүлэх үйл ажиллагаа

МТИТ-ийн тасаг:

ЦА-ны үндсэн үйл ажиллагааны цахим сүлжээний нийтлэг журам, ЦССҮТ, ЦСТ ялгаа, нууцлал, цусны албаны баримт бичгийн цахимжуулалт, нууцлал, нэвтрэх эрх, авч ашигласан бүртгэл, аюулгүй байдал

Завсар үйлчилгээ удирдлагын тогтолцоо, хүйтэн хэлхээний хяналтын тогтолцоо,

Эмнэлгийн болон эмнэлгийн бус тоног төхөөрөмжийн арчилгаа, үйлчилгээ, тохируулга, баталгаажуулалт, завсар, үйлчилгээ, алба, тасаг, Цусны салбар төвөөс хүсэлт хэрхэн хүлээн авах хэрхэн шийдвэрлэх

Хэрэглэгч, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж судалгаа, нийцүүлэх үйл ажиллагаа

СТСБ-ийн алба: Цусны албаны стратеги төлөвлөлт, маркетинг, үйл ажиллагааны тайлан мэдээ авах, нэгтгэх, тайлагнах, буцаан мэдээлэл түгээх, санхүү бүртгэл, өр авлага, үйл ажиллагаанд шаардлагатай бараа, материал хэрэгслийн нөөцийн хэмжээ, нөхөн хангалт, хадгалалт, захиалга, олголт, тээвэрлэлт, хадгалалт, зарцуулалтын бүртгэл, тайлан

ЭШХНХА-ны алба: ЦА-ны хүний нөөцийн сан бүрдүүлэлт, нийтлэг шаардлага, эмч мэргэжилтний судалгаа, мэргэжил, мэргэшил, гадаад, дотоод сургалтанд хамрагдсан бүртгэл, мэргэжлийн болон эрдмийн цол хэргэм, хийгдэж байгаа судалгаа, шинжилгээ,

ЧЦСС-ийн алба: Чанарын менежментийн тогтолцоо, баримтжуулалтын тогтолцоонд тавигдах нийтлэг шаардлага, үзүүлэлт, шалгуур, аудит, хяналт үнэлгээ хийх удирдамж, нийтлэг шалгуур, жишиг загвар

Цусны албаны үйл ажиллагааны ХСХ, эрсдлийн нийтлэг асуудлууд, эмч, мэргэжилтэн, цусны доноруудад тавигдах нийтлэг шаардлага